

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2013 оны 05 дугаар сарын 03

Тендер шалгаруулалтын нэр: **Баянхонгор суманд шинээр баригдах "Хонгор-1000" орон сууцны хорооллын цахилгаан хангамжийн 6 кВ-ын ЦДАШ, дэд станц шинээр барих /Баянхонгор/ ажлын нэг маягийн зураг, альбомыг үндэслэн зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.**

Тендер шалгаруулалтын дугаар: **ХААГ-А-2013/ХҮIII-06**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг **Худалдан авах ажиллагааны газар** нь эрх бүхий тендерт оролцогчдоос **"Баянхонгор суманд шинээр баригдах "Хонгор-1000" орон сууцны хорооллын цахилгаан хангамжийн 6 кВ-ын ЦДАШ, дэд станц шинээр барих /Баянхонгор/ ажлын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил"**-ыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **200,000 (хоёр зуун мянган)** төгрөгийг тушаан худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жилийн борлуулалтын орлогын дундаж нь санал болгож буй үнийн дүнгийн 50%-с доошгүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:

Санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 3 жил буюу 2010, 2011, 2012 он.

Сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 3 жилийн аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй ижил төстэй ажил гүйцэтгэсэн байна.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм

- Зураг төсөл боловсруулах байгууллага нь:

1.3.3. Цахилгаан дамжуулах гол шугам, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг /35 кВ хүртэл/ боловсруулах Тусгай зөвшөөрөлтэй байна.

- Барилга угсралтын ажил гүйцэтгэх байгууллага нь:

03.2.1: 0,4-10 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт засвар, бусад дагалдах үйлчилгээ үзүүлэх Тусгай зөвшөөрөлтэй байна.

Тендерийн хамт **10,000,000 (арван сая)** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2013 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 10:00 цагаас өмнө** доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2013 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх **эрхгүй.**

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү **тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

14193 Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Их тойруу 80/1

Нэг цэгийн үйлчилгээ, Утас: 70111090, 70125060

www.e-tender.mn, www.procurement.gov.mn

www.e-procurement.mn